

өөрчлөлт болсон юм. Тэр үед юм хүм, зарим бичиг цаас нэлээдийг устгахсан. Эмхэлж байгаа нь энэ гээд их тааруу муу юм хийсэн. Их юм алга болсон. Жишээ нь Тувагийн хилийн тухай нэг мундаг газрын зураг байдаг байлаа. Тэр зураг алга болсон гээд яриад байвал зөндөө л юм бий. Ингээд яриагаа өндөрлөө дөө.

#### Бу Даццэрэн

Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд

#### Ц.Дэмиддагва

Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд

### Д.АДИЛБИШ ГУАЙН ГЭГЭЭН ДУРСГАЛД

Дашийн Адилбиш 1917 оны гуравдугаар сарын 16-нд Өвөрхангай аймгийн Төгрөг сумын нутагт төрж, бага наснаасаа сумын хоршоо, цэргийн гар үйлдвэр, монгол тээх, Улсын Бага хуралд биеийн хөдөлмөрийн ажил хийж, хөдөлмөрийн амт шимийг хүртэж, амьдралын их замаа эхэлжээ.

Хөдөлмөр хийхэд юуны өмнө эрдэм боловсрол зайлшгүй хэрэгтэй тул Д.Адилбиш Москва дахь дорно дахины дээд сургуульд орж 1942 онд төгсгөөд МАХН-ын төв алпаратад зааварлагч, халтсийн дарга, 1946 оноос МУЭТЭ-ийн дарга, 1950 оноос ЗХУ-д (хуучин нэрээр) ЭСЯ-ны зөвлөх, дараа нь мөн улсад болон Зүүн Европын социалист гэгдэж байсан орнуудад элчин сайд, 1956 оноос ГЯН-ны сайд, 1957 оноос Унгарт элчин сайд, 1961 оноос Намын Төв Хороо, Засгийн газрын үйлчилгээ, аж ахуйн газрын дарга, 1962 оноос Энэтхэгт элчин сайд, 1963 оноос ЭТНБХГХ-ны дарга, 1973 оноос Югославт элчин сайдын өндөр хармуцлагатай албыг нэр төртэй хашиж байгаад 1988 онд өндөр насны тэтгэвэрт гарч 1992 оны наймдугаар сарын 21-нд таалал төгсчээ.

Адилбиш гуай ноогдуулсан албан үүргийг биелүүлэхдээ явмалт "Монгол эх орныхоо төлөө" гэсэн халуун сэтгэлээр өөрийн мэдлэг, хүч чадал, ажлын арвин баялаг туршлагаа дайчлан зүтгэж байсан тул ажил нь өөдрөг, өмнөө тавьсан зорилгоо нэр төртэй биелүүлж байсан юм. Түүнийг ойн баврын дурсгалын медалиас эхлээд Сүхбаатарын одон, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд цолоор шагнажээ.

Адилбиш гуай төрөлхийн уужуу сайхан ухаантай, олон улсын болон өөрийн орны байдал, төлөвийг маш нарийн ухаарч, ажилтайгаа холбогдсон зүйлийг тал бүрээс нь нямбай судалж, амьдрал ямар чигт явж байгааг дүгнэн цэгнэж, түүнтэй уралдан ажилладаг төрийн том

ЭНЭТХЭГТЭН байлаа. Түүнийг 1956 онд ГЯН-ны сайдаар томилсон үе бол манай гадаад харилцаа хязгаарлагдмал хүрээнд өргөжих төлөвтэй байсан боловч нэг хэт их гүрний эрхшээлд хэтэрхий орсон, дотооддоо тарсчлох, бусдыг хуулах компани ид хүчээ авч байсан үе юм. Адилбиш гуай тэр үед өөрийн орны гадаад харилцааг харилцан адил тэгш байх нэгдсэн дээр орон бүхэнтэй элдэв ялгаваргүй хөгжүүлэхийг чармайж байсан юм. Үндэсний хэл бичиг, соёлоо эрхэмлэн хөгжүүлэхийг эмгэж, ялангуяа монгол хэл бичгээ гадаад харилцааны болон өдөр "Төрийн ажилд оновчтой хэрэглэхийг эрмэлздэг байсан юм. Тэр үед Төрийн албан ёсны цуглаан дээр Адилбиш гуай "Бид ус зөөдөг машин дээрээ вода, талх зөөдөг тэргэн дээрээ хлеб гэж бичдэгээ болгимоор бидна" гэсний төлөө "Ленин-Сталины хэлийг хэрэглэхэд юу нь буруу байна" гэсэн зэмлэлийг дээрээс хүртэж байв. Тавиад оны дунд, түүнчлэн сэхээтний тухай яриа идэвхжиж байхад манай удирдагчид "Турмаг өгөшүүлэн" ...хэлэх ярих юмаа бид нарт чөлөөтэй ярь" гээд нь дээд сургууль, албан газруудад сэхээтний яриаг сонсох хүмүүсийг тэмцлэн явуулж, байдаг бүгдийг нь хэлүүлж аваад эцэст нь тогтоол гаргаж "сэхээтний төөрөгдөл" гэчийг буй болгож тааламжгүй хүмүүсээ сэтгэгдүүлж эхлэхэд Адилбиш гуай "Энэ хэл яриа гаргаж байгаа сэхээтнүүд бол нам, засаг, ард түмэндээ буруу санагддаа биш, тус орноо түргэн хугацаанд сайн сайхан болгохсон гэсэндээ чин сэтгэлзсээ ярьж байгаа хүмүүс" гэж сэхээтнээ тууштай хамгаалж байлаа. Д.Адилбиш аливаа асуудалд тэвчээртэй, буйр суурьтай сэхээтний хамт бусдад бууж өгөхгүй, долгинохгүй, хэлэх гэсэн юмаа гээд ч хаана ч зоригтой хэлж чаддаг нь түүний сэтгэхүй, ухааны чадвар байсан юм.

Гадаад харилцаа хязгаартай хөгжих үе эхэлж байсан тэр цагт жонголчуудын туйлширдаг зуршил мөн л хүчтэй илэрч олон улсын харилцаанд хэвшин явагдаж ирсэн харилцааны хэм хэмжээг үл хайхрах юм үү, айл зэргэлдээ нэг гүрний нэг үндэстэн шиг байхыг хичээх, бид гадаад бодлогоо нэг загварт, нэг үзэл санаанд захируулахыг эвэлдөг, өөрийн онцлог, өөрийн хөгжлийн хэмжээ, хүн амын тоо, газар зүйн байршил энэ бүгдийг үл хайхрах явдал засаг төрийн дээд зорилго, яам, газрын удирдагчдын түвшинд тод илэрч байсан юм. Харин Адилбиш гуай бол өөрөөр хандаж, өөрийн гэсэн гадаад бодлого баримтлан ажиллахыг хичээж байлаа.

ГЯН-ны сайдын хувиар гадаад бодлогыг хэрэгжүүлэхдээ аль болох олон сайн тунш улстай, дайсанлагч улсгүй байхыг хичээж байв. Энэ бол үнэндээ зөвсэлд үл нэгдэх чиг шугам байсан юм. Мөн социалист лагерь гэж байхад түүнд багтаж байсан орон бүхэнтэй адил

тэлц, эв найртай харилцахыг зорьж байсан нь ноёрхогч их гүрэн, түүний дуулгавартай төлөөний хүмүүс болсон манай нам, төрийн зарим удирдагчийн дүрлэг хүргэж байв. Иймээс Адилбиш гуайг ад шоо үзэх явдал олонтаа гарч байсан юм. Адилбиш гуай түүнд шантралгүй, өөрийн зарчимч байр сууринаас өчүүхэн ч няцалгүй ажиллаж байсан нь төрийн ноён нуруутай болохоо харуулж байсан хэрэг. 1958 онд Югославын коммунистуудын холбоо өөрийн мөрийн хөтөлбөрийг боловсруулан хэлэлцэж байхад манай нам, засгийн зарим удирдагчид бусдыг дууриан, Югославынхны дотоод хэрэгт эрээ цээргүй хөндлөнгөөс оролцож, түүгээрээ захирагч гүрний өмнө гавьяатан болохыг хичээж байв. Тэрхүү мөрийн хөтөлбөрийг хэлэлцсэн Югославын коммунистуудын холбооны VIII их хуралд МАХН-ын Төв Хороо Д. Адилбишийг ажиглагчаар оролцуулсан юм. Тэр хуралд Югославын МАХН-ыг шүүмжилсэн зүйл илтгэлдээ ч мөрийн хөтөлбөртөө ч оруулаагүй тул Адилбиш гуай бусдыг дагалдан хурал хаяж гарсангүй. Гэтэл МАХН-ын Төв Хороо социалист орны төлөөлөгчид хурал хаяж гарсан байхад Д. Адилбиш тэднийг даган гарсангүй, Югославын ревизионистуудыг шүүмжилж тэмцсэнгүй гэх түүнийг буруутган зэмлэж, Төв Хороонд энэ хурлын талаар ирүүлсэн илтгэлийг нь буруушааж, Унгараас Югославыг хавсран суугаад 2 жил ч болоогүй байхад нь түүнийг татан дуудсан болно. Гэтэл бодит үнэн хэвээрээ үлддэг тавилантай болохоор өнгөрөн улирах цаг Адилбиш гуайд бурууг ноогдуулсангүй, харин буруугүйг буруутгасан цаасан тогтоол хогийн саванд хаягдсан юм. Ер нь Монгол, Югославын харилцаа цаг үеийн элдэв нугачаа, сорилтод үл өртөгдөн өдгөө хүртэл хэвийн сайн явагдаж ирснийг Адилбиш гуайн гавьяа гэхэд хэтрүүлээ болохгүй биз ээ.

Адилбиш гуай ЭТНБХГХ-нд ажиллахдаа улс түмний эв нэгдлийг бэхжүүлэх, ялангуяа Монголтой эв санааны нэгдэлтэй байхыг эрмэлзсэн ард түмний сэтгэл зоригийг халуунаар утган авч гадаад орнуудтай тогтоосон найрамдлын нийгэмлэгүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, заримыг шинэчлэн байгуулж, төлөөлөгчид илтгэх үзэсгэлэн, хэвлэл, кино солилцох явдлыг эрчимжүүлж байв. Плануулагдайсан улс гэгдэж байсан Япон мэтийн орон болон хөрөнгөтөн, хөгжиж байгаа улсуудын ард түмэнтэй монголын ард түмний эв санааг илэрхийлэн ойртоход жинтэй хувь нэмэр оруулж байсан юм.

Д. Адилбиш бол зөвхөн улс төрч байгаагүй, аж ахуйн ажлыг сайн мэддэг, өөрөө мэргэжлийн өндөр түвшинд машин жолоодохоос эхлэн аж ахуйн бүх төрлийн ажилд биеэр оролцдог байсан юм. Түүний санаачилгаар өөрийн байгууллагын хүч хөрөнгөөр ЭТНБХГХ-ны

барилсан нь одоо хүртэл үр ашгаа өгсөөр байна.

Унгар улсад манай анхны ЭСЯ-ны байрыг олж тохижуулах ажлыг мөргөн гардан хийсэн билээ. Юмыг шинээр сэтгэн санаачлахдаа хэнийг ч дагуулдаггүй байв. Будалешт дахь ЭСЯ-ны хашаа, цэцэрлэгийг тохижуулан зуны халууд болдог үндэсний баярын хүлээн авалтыг гадна "гарден парти" маягаар хийсэн нь ганц манай хувьд ч бус. Бүх Будалештийн хувьд шинэлэг зүйл болж, гадна, Дотны зоочдын сайшаалыг хүлээж байлаа.

Адилбиш гуай хамт ажиллаж байсан залуучуудынхаа урам зоригийг хөгжөөж, тэдэнд түшиглэн, бүрэн итгэл өгч, ажил хэргийг бодит байдалтай уялдуулан дороос гарах санаа бодлыг ямагт ангардаг байв. Тэр ГЯД-ны сайдын ажлыг дөнгөж хүлээн авч байсан мөчид ЗХУ-д олон улсын харилцааны дээд сургууль төгсөөд төв албартадаа ажиллаж байсан хэсэг нөхдийг Зөвлөлтөд гадаад хэл мэдлэг сургаххаар явуулах шийдвэр гарчихсан байж. Тэрээр "та нарыг сургуулах шийдвэр гарах үед би энд байсан бол татгалзах л байсан. Та нар цөм хойно сурсан шүү дээ. Зөвлөлтийн мэргэжилтэн гээд мөчид ажиллаж байгаа хүмүүсээс юугаараа дутуу юм бэ. Хэрвээ гэсэн зорилгод ашиг тус өгөхгүй бол дуртай цагтаа буцаад ирээрэй" гэж байсан юм. Тэр үед Адилбиш гуайгаас өөр ийм үг хэлэх хүн байхгүй байсан гэхэд хилсдэхгүй буй заа.

Адилбиш гуай хилийн чанадад ажиллаж байхдаа эх орныхоо илдэвэр, хөдөө аж ахуй, худалдаа, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн эрмэлзлэлтэй олон зүйлийг судлан ямар салбарт, ямар оронтой хамтран ажиллавал Монголд ашигтай болох талаар өдий төдий судалгаа хийж, санал тооцоо, эд материалын загвар ирүүлж байлаа. Ийм зүйлийг мөчид удирдагчид даан ч тоомсоргүй өнгөрөөж байсан нь улс орноо эвч улсын гарт аль болохоор лав оруулахыг эрмэлзэж байсантай холбоотой байсан болов уу. Зөвлөлтөөс өөр орны авто машин Монголд эх-ирэхийг хориглож байсныг санахад хөгтэй үе байж шүү дээ. Монгол орноос монголын ард түмний эрх ашгаас зарим талаар ухарсан арчаагүй эргэлт, Сталинизмын харгис дарлал нурах тавилантайг эрүүл саруулж, манай эх оронч дипломатч нөхдийнхөө адилаар Адилбиш гуай аль эрт ойлгон, мэдэрч байсан юм. Гэхдээ одоо бидний байгуулж байгаа нийгэмд муу зүйл, бас муулаад байгаа нийгэмд сайн зүйл байдгийг мэдэрч сайныг авч саарыг гээхийн арга ухааныг чадамгай эзэмшээд түүнд дээр өөрийн орны онцлогийг харгалзсан гадаад бодлого явуулж эвсгэл алдаа бага, оноо элбэг байхыг Адилбиш гуай ойлгож байсан аж ахуйтай.

Сүүлийн гурван жилийн байдлаас харахад Монгол оронд,

Монголын ард түмэнд үүрдийн дайсан улс, үүрдийн хань-найз улс гэж байхгүй нь илт боллоо. Харин монголын ард түмэнд, түүний гадаад бодлогыг хэрэгжүүлэгчдэд үүрд санаж, хором ч мартаж болохгүй, хаана ч бичигдээгүй буюу бичигдэхгүй хууль болсон тийм зүйл байгаа нь илт юм. Үүнд улс орны бүрэн эрхт байдал, газар нутгийн халдашгүй байдал, Монгол үндэстний хэл, соёл, уламжлал, монгол хэлтэн-үндэстний олон үед амьдрах боломж, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдал гэх мэт хэд хэдэн зүйл багтах биз ээ. Энэ аугаа их хууль үнэт зүйлээс гажвал хэн ч байсан монголын дипломатч байхувьгүй. Аман дээрээ сайхан үг хэлж, ажил дээрээ урвуу үйлдэл хийдэг өнгөрсөн үеийн удирдагчидтай Адилбиш гуай өөрийн боломжийн хэрээр тэмцэж байсан. Чин үнэнээр хэлэхэд хамгийн том удирдагчаасаа эхлээд өчүүхэн холбоо залгуулагчаа хүртэл харь ил гүрний төлөө ажиллагчид манайд бишгүй байсан шүү дээ. Монгол Америкийн хооронд дипломат харилцаа тогтоох гэж байсан эхний үед юу болж байсныг гадарлах хүмүүс олон бий. Тэр үед манай ард баригчид гэм буруутай этгээдийг зэмлэсэн үү. Тэднийг илрүүлж арга хэмжээ авсан уу. Үгүй. Огт үгүй. Одоо манайд тийм хүмүүс байхгүй гэх баталгаа байна уу. Үгүй, огт үгүй.

Эзэн Чингисээс ч өмнө Монгол хүн өлгий болсон газар нутаг, улс нуруу, тал хээр, хүн амын ундаа болсон тойрон бүрд, ус нууруудад юунаас ч илүү үнэтэйд тооцож, ард түмнийхээ эрх ашгийг бүгдээ илүү дээдэлж ирсэн нь сайхан уламжлал билээ. Монголын газар нутаг улс орны бүрэн эрх, тусгаар тогтнолыг ямар хүч бүрэлтэн сүйтгэж байсан бэ? Үүнийг түүх бидэнд тодорхой сургацаар байна. Манжийн хаад монголчуудын дотроос аль тэнэг, боловсрол нимгэн, алба тушаал, эд хөрөнгө, мөнгө, архи, хүүхэнд ухаан алддаг хүмүүсийг шилэн сонгож тэднээр эх оронч, оюуны өндөр чадавхитай, улс орноос гэсэн ухамсартай, ард түмнээ гэсэн сэтгэлтэй бүхнийг устгуулж байсан нь бодит үнээн. 1921 оны хувьсгалын дараа ч дээрхтэй адил байдал давтагдсан биш үү. Өөрчлөлт шинэчлэлийн одоо үед ч гэсэн бид бүх улс түмэнтэй эв найрамдалтай байхын хамт, улс орны эрх ашигтай холбогдсон аливаа асуудалд бага жижиг гэхгүй тун ч нямба хандаж ирээдүйдээ муу нөлөө үзүүлэх тийм зүйл гаргаж хэрхэв болохгүй билээ. Монголд урьд өмнө гарсан хэлмэгдэл одоогийн Орос хамаагүй гэснийг бид даган баяссан явдал харамсалтай хэрэг билээ. Орос улс ЗХУ-ын олон улсын өмнө хүлээсэн бүх үүрэг хариуцлагыг өөртөө бүрэн хүлээн авч байгаагаар бүх дэлхийн өмнө зарлаж тунхаглаж НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Байнгын гишүүний байгуулийг эзэлснийг хэн ч мартаагүй. Нөгөө талаар ЗХУ-ын үйлдсэн

Орос хамаагүй юм бол "мөнгөн өр төлбөр" гэгч яагаад тэр орны хооронд хэвээр үлдэж цааш яригдах асуудал болон үлдэж байгаа юм бэ гэсэн асуулт зүй ёсоор гарч байна. ЗХУ-ын нам, төрийн удирдагчдын шууд заавраар, тэдний мэргэжилтэн зөвлөхүүдийн зөвлөлтөөр устгасан 700 гаруй сүм хийд, эрдэм соёлын өдий төдий зүйлс бүтээлүүд, нам, төрийн нэрт зүтгэлтэн, лам хуврагууд, ман ард олон болон үндэсний оюун санааны уламжлал зэрэг үнэт зүйлс хэдэн зуун тэрбум доллараар ч үнэлж барахгүй зүйлс байв. Үүний зэрэгцээ өдгөө хэдий өөр цаг үе ч гэсэн урьдын их хэргэдүүлэгчид, устгагчдын буурь суурийг залгамжлан үлдсэн зүйлс энэ гунигт явдалыг зөвхөн хамтран харамссанаар бид л хэргийг ямар хэмжээнд тавьж байна вэ. Нөгөө талаар Орос улс ЗХУ-ын учруулсан хэлмэгдлийн төлөө Унгар, Япон, Польшийн гэм буруугаа хүлээн, уучлал гуйж энэ талаар хамтран гаргасан зорилт бичигтээ тусгасныг дэлхий дахин мэднээ. Энэ бүгдээс харахад бид аанай л хуучин замаараа явж байгаа биш үү.

Орчин үед гадаад харилцааны бүхий л асуудлыг цоо шинээр шийдвэр шийдвэрлэх нь нэн тэргүүний зорилго болжээ. Аливаа зүйлс нөхцөлд улс орны эрх ашгийг хохироосон дутуу дулимаг аргаар гаргаснаас тийм шийдвэр гаргахгүй, ухаалаг чиг хандлагыг баримтгаж болгож, дараагийн шатанд үлдээх нь хавьгүй дээр байж болно.

Бүрэн зэргэлдээ хоёр их гүрэнтэйгээ эв найрамдалтай оршин сууна гэсэн мэднээ. Харин найрамдлын нэрийн доор манай ард түмэн хэрхэн хэрхэн юу алдсанаа хатуу ухамсарлан шинэ нөхцөл байдалд улс орны эрх ашигт тохиолдож байгаа сөрөг бүхнийг давтахгүй, зөрөг бүхнийг дэмжин дэлгэрүүлэхийг хичээх ёстой.

Энд дурдсан энэ мэтийн зарим асуудалд Адилбиш гуай тун ч анхааралтай хандаж, нөхөдтэйгээ маш тодорхой зөвлөж, үйл ажлаа баримтгаж байсан тул түүний гэгээн дурсгалыг хүндэтгэхдээ манай ард түмэн сэтгэдэг, боддог байсан утгын аясаар санаанд буусан зүйлийг цухас дурдсанд уншигч та эмзэглэхгүй биз ээ гэж бид хүсьеэ бэлэн байна.

Монгол улсын гадаад харилцааны түүхийг үнэн зөвөөр томъёолох Адилбиш гуай шиг төрийн зүтгэлтний үйл хэрэг зүй ёсоор үнэлж үнэмлэх нь дамжиггүй.

## ДАЙНД ОРОЛЦСОН ТУХАЙ ДУРСАМЖ

### НЭГ. 1945 ОНЫ ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД ОРОЛЦСОН МИНЬ

Би 1943 онд ЗХУ-ын Дотоод явдлын ардын комиссариатын Ф.Э.Дзержинскийн нэрэмжит Харьковскийн хилийн цэргийн дунд сургуулийг төгсгөж ирээд ДЯД-ны дотоодын ба хязгаарын цэргийн нэгдсэн сургуульд багш, штабын даргын ажлыг 1951 оны 9 дүгээр сар хүртэл хийсэн юм. Энэ хугацаанд дээрх сургуулийн суралчдыг хил хязгаарт дадлага хийлгэх ажлыг бараг жил дараалан удирдаж, хил хамгаалах ажлыг биечлэн хийж байв. 1945 онд тус сургуулийн хил хамгаалах Халх голын 24 дүгээр отрядад дадлага хийлгэж байхад японы эсрэг чөлөөлөх дайн болов.

Би отрядын улс төрийн орлогч Балжинням агсны хамт заставуудаар явж ажиллаж байв. Тэр үед зөвлөлтийн цэргүүд баруун-фронттоос татагдан манай хилийн дагуу байрлаж, японы эсрэг дайнд ороход бэлтгэж байсан юм. Халх голын районд Беларусьийн 3 дугаар фронтын цэргүүд байсан бөгөөд тэд маш ширүүн догшин, дайны галын дунд явж санаа сэтгэлээр унасан, ёс суртахууны хувьд ихээхэн эвдэрсэн дайчид байсан. Энэ учраас заставын хонь, мал, ялангуяа тугалыг алж идэх дуртай, нутгийн айлуудын болон заставын тугалыг бэлчээрээс нь ангидаа аваачиж иддэг, энэ тэрийг ярих юм бол бу гарган хий бую тавьж сурдүүлэх зэргээр айлгадаг байлаа. Тэр байтугай өөр хоорондоо буудалцдаг байсан.

Манай заставын дарга, цэргүүд орос хэл мэдэхгүй, оросууд монгол хэл мэдэхгүй учир хэл амаа ололцох нь түвэгтэй байв. Сүүлд сүүлдээ оросуудын булгааж авсан малын төлөө ярилцдаг хүн бол л болж хувирав. Эхний үед тэд буулт хийхгүй, авсан малаа буцаа өгөхгүй, юм л бол бую гаргадаг байсан ба би ч бас буугаа гарга айсан сүрдсэн шинжгүй байвал арай дээр байдаг байсан юм. Гэтэл дугаар сарын сүүлчээр орос цэргийн нэг дивизийн штаб Нөмрөгийн заставт байрласан учир дивизийн дарга хошууч генерал Палчанов улс төрийн хэлтсийн дарга Южеков нартай дотно танилцаж малт дээрэмтэй тэмцэхэд би "хүчтэй" хүн болсон юм.

Би 1945 оны 8 дугаар сарын 7-нд Нөмрөгийн урд заставт байхад байтал дивизийн дарга Палчанов нан даруй уулзахыг хүсч застав

болгоогоор дуудав. Балжинням бид хоёр Нөмрөгийн заставт очиж генералтай уулзгал: Тэр "... шөнийн 00 цагт дайнд орно. Маргааш заставыг япончууд бөмбөгдөж их буугаар буудна байх. Та нар шөнийн турш гүн окол малгаж, хориглон хамгаалалтыг сайн байлган хамт заставын мал, гэр бүлийн хүмүүсээ гүнд холдуулах гэжтэй..." гээд дайн зарлаж В.М.Молоотовоос хэлэх үг, Москвад байгаа японы элчин сайдад гардуулах ноот бичиг зэргийг үзүүлэв. Энэ тухай отрядын дарга баатар Чогдонд мэдэгдэж генералын ёсоор бүгдийг хийж шөнийн өнгөрөөв. Үнэхээр шөнийн 00 цаг болж зөвлөлтийн цэргийн онгоцууд үй олноор зүүн зүг одож Нөмрөгийн заставын хойд талаар Халхын голд резин гүүр тавьж танк-орчим орос цэргийн нэг дэд хурандаа, дэслэгч, 2 цэргийн хамт суралцан ирж улмаар генерал Палчановтой уулзуулав. Генерал Палчанов нэлээд сэтгэл нь зовсон байдалтай "... Халхын гол үертэй байна. Зэргэлдээ ангиуд нэлээд урагшлав бололтой. Халх голын цэргүүд гол гарч чадахгүй байна. Ах дүүгийн ёсоор та туслахыг хүсэж байна..." гэв. Дайсан этгээд харагдахгүй, хамт дадлгүй байсан учир Палчанов бухимдсан байдалтай байв. Балжинням бид хоёрын дэргэд салбар ангиудын командлагч нарыг үзэж ил гаргаад зүүн уулын хаяанаас дороос нь дээш нь Халх голын дээгүүр бууд..." гэж тушааж байв. Генерал ёсоо бол Украин хүн байсан байх. Тэр сайн зам (дорооха) тэд шууд замаар явж том хүчтэй тулалдахан гэж бид нарт байв. Бид заставтаа эргэж ирээд Нөмрөгийн заставын морьдыг дэчөөд цэрэг, төв сургуулийн 5-6 суралчдыг оролцуулан төв цэргийн сумангийн улс төрийн орлогч Бираадамба, отрядын дарга Банди, заставын дарга Тогтог, улс төрийн орлогч нараар толгойлуулан бүлгүүд зохион байгуулж зөвлөлтийн цэргүүдийг мориор гол гаргаж эхлэв. Орос цэргүүдийн олонхи үзээгүй учир сэлж байгаа моринь амьг татан хөл алдаж явж байв. Энэ учраас орос цэргүүдийг морь уннуулж дэл, морь нь барилдан усны гармыг алдахгүй даган, өөрсдөө хөтлөн цэргийн зэрэгцээ хүнд, хөнгөн пулемёт, миномёт, дайзтай сум бид өөрсдөө гол гаргаж байв. Өглөөний 5 цагас 14 цаг хүртэл 2 батальоныг гол гаргалаа гэж оросын дарга нар хэлж байв. Тэд бид нарт маш их баярлаж, зүүж явсан бую, дурантаа байв. Бид дайнд явж байгаа нөхдөөсөө юм авахгүй гэж болговч тэд шууд зүүж өгч байсан юм. Намрын морьд тарган